



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 21-ны өдөр

Дутざар 197

Эрээнээс

Г Эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын "Журам батлах тухай" 2017 оны А/207 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус батласугай.
2. Журмын дагуу эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, эхийн эндэгдлээс сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Эх барих, эмэгтэйчүүдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /П.Хишгээ/, аймгийн Эх барих эмэгтэйчүүдийн еренхий мэргэжилтэн, зөвлөх эмч /Л.Ганболд/ нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.
4. Уг тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2012 оны А/51 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны
09 дүгээр сарын 21-ны өдрийн
~~10~~¹¹ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга: Эрүүл мэндийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Эх барих, эмэгтэйчүүдийн тусlamж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн

- Гишүүд:
- Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусlamж үйлчилгээний
хэлтсийн дарга
 - Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
 - Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарын
асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Эрүүл мэндийн газрын анхан шатны тусlamж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн
 - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
 - Эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмч
 - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмгэг судлаач эмч
 - Шаардлагатай тохиолдолд дотрын болон бусад мэргэжлийн
ерөнхий мэргэжилтэн

Эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлийн журам

Нэг. Ерөнхий зүйл

Жирэмсний хугацаанд болон төрөх үед эсвэл жирэмсэн төгсгөвер болсноос хойш 42 хоногийн дотор жирэмсний байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмсэн, төрөлт, түүнийг удирдахтай холбоотой шалтгаанаар эмэгтэй нас барагыг эхийн эндэгдэл гэнэ. Эх барихын ба эрхтэн тогтолцооны эмгэгүүд, эмнэлгийн болон эмнэлгийн бус нехцөлд хийгдсэн үр хөндөлт, зулбалт, умайн гадуурхи жирэмсний улмаас нас барсан тохиолдол эхийн эндэгдэлд орно. Харин золгүй тохиолдлын шалтгаантай нас баралтыг эхийн эндэгдэлд тооцохгүй. Эхийн эндэгдэлд нөлөөлсөн хожимдол, шалтгаан, дүгнэлт, үзүүлсэн тусlamж үйлчилгээг нягтлан дүгнэлт, сургамж, зөвлөмж гаргах, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах замаар эхийн эндэгдлээс сэргийлэх

Хоёр. Эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлийн үүрэг

1. Эх эндсэн тохиолдол бүрийг мэдээллийн урсгалын дагуу 24 цагийн дотор мэдээлж, эмгэг судлалын шинжилгээнд хамруулсан эсэхэд хяналт тавих.
2. Эмнэлзүй эмгэг судлалын конференцээс гаргасан сургамж, зөвлөмж, шийдвэр болон эхийн эндэгдлийн талаарх холбогдох байгууллагуудаас ирсэн баримт бичгийг цуглуулах, нэгтгэх, үнэлэх
3. Эхийн эндэгдлийн тохиолдол бүрд хэлэлцүүлэх асуудлын дэг, хугацааг товлон эхийн эндэгдлийн хэлэлцэх зөвлөлийн гишүүдэд зар хургуулэн хурлыг хуралдуулах,
4. Эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлийн хурлаар эмнэлзүй эмгэг судлалын конференцээр хэлэлцсэн асуудал, эхийн эндэгдэлд нөлөөлсөн хожимдол, шалтгаан, дүгнэлт тус бүрийг нягтлан хэлэлцэж, эцсийн дүгнэлт, сургамж, зөвлөмж, цаашид хийх ажил, авах арга хэмжээний талаар шийдвэр гаргах,
5. Сургамжинд тулгуурлан аймгийн түвшинд эхийн эндэгдлийг дахин гаргахгүй байх талаарх үйл ажиллагааны чиглэлийг тогтоон хурлын шийдвэрт тусгах
6. Эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, биелэлтэнд хяналт тавих, үр дүнг тооцох
7. Эх эндсэнээс хойш 40 хоногийн дотор эхийн эндэгдлийн тохиолдлын бүх материалын хуулбар, эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлийн хурлын шийдвэрийн

хамт 2 хувилан Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /ЭХЭМҮТ/-ийн Тандалт судалгааны алба, Эрүүл мэндийн яам /ЭМЯ/-ны Эх барих змэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөлд албан тоотоор хүргүүлэх

Гурав. Эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлийн эрх

1. Эхийн эндэгдлийг хэлэлцэхэд шаардлагатай материалыг холбогдох байгууллагаас цаг хугацаанд нь гаргуулах, шаардах

2. Эхийн эндэгдлийг тооцох, бүртгэх, мэдээлэх, хэлэлцэх, шийдвэрийг хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд хяналт тавих